

**НЭГ. ДЭЛХИЙН БАНКНЫ “МАЛ АЖ АХУЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТИЙГ  
НЭМЭГДҮҮЛЭХ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(2020 оны жилийн эцэс)

| №           | Хөтөлбөр/төслийн агуулга  | Гүйцэтгэл  |  |             |       |
|-------------|---|--|--|-------------|-------|
| 1           | Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана) | Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл 6508-MN<br>Төслийн зорилго: Малын эрүүл мэнд, үр ашиг, бүтээмж болон төсөл хэрэгжих газрууд дахь нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх. |  |             |       |
| 2           | Санхүүжилтийн эх үүсвэр   | Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээл.  |  |             |       |
| 3           | Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа   | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ,<br>Хэрэгжих нийт хугацаа- 5 жил  |  |             |       |
|             |   | Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: НҮБ, ХХААБ, МЭЕГ   |  |             |       |
| 4           | Төсөл, хөтөлбөрийн зорилтууд  | Зорилт 1: Төсөл хэрэгжиж буй бүс нутаг дахь гоц халдварт өвчнүүдийг багасгах (хувь),   |  |             |       |
|             |   | Зорилт 2: Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх (махан болон сүүн бүтээгдэхүүн) (хувь),   |  |             |       |
|             |   | Зорилт 3: Малын гаралтай бүтээгдэхүүний инфляциас цэвэршүүлсэн үнэ цэнийг нэмэгдүүлэх (хувь)   |  |             |       |
| 5           | Зардал  | Төсөв (Нийт зардал)  | Төслийн 4 бүрэлдэхүүн хэсэг болон удирдлагын зардалд 2020 оны жилийн эцсийн байдлаар 5,767,344,800.0 төгрөг төсөвлөж, 5,257,792,655.0 төгрөг зарцуулж 91.2 хувийн биелэлттэйгээр санхүүжилтийг зарцуулсан байна. |             |       |
|             |   | Үүнд:  | Төсөв (2020 он)  | Гүйцэтгэл   | Хувь  |
|             |   | Бүрэлдэхүүн хэсэг 1  | 4,641,956.0  | 4,529,000.0 | 97.6% |
|             |   | Бүрэлдэхүүн хэсэг 2  |  |             |       |
|             |   | Бүрэлдэхүүн хэсэг 3  | 1,125,388.8  | 728,792.66  | 64.8% |
|             |   | Бүрэлдэхүүн хэсэг 4  |  |             |       |
|             |   | Удирдлага  |  |             |       |
| <b>Нийт</b> |   | 5,767,344,800.0  | 5,257,792,655.0  | 91.2%       |       |
| 6           | Төсөл, хөтөлбөрийн зорилт:  | Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ  |  |             |       |
|             | 1-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд:  | Үнэлгээний тайлангийн 7-10 дугаар хуудас.  |  |             |       |
|             | 2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд:  | Үнэлгээний тайлангийн 10-11 дүгээр хуудас.   |  |             |       |
|             | 3-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд:  | Үнэлгээний тайлангийн 12-15 дугаар хуудас.   |  |             |       |

|    |  |   |                     |                     |                     |                     |
|----|--|---|---------------------|---------------------|---------------------|---------------------|
|    | 4-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд:   | Үнэлгээний тайлангийн 15-17 дугаар хуудас.  |                     |                     |                     |                     |
| 7  | Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)  | <p>Дүгнэлт.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. НҮБ, ХХААБ-тай байгуулагдсан гэрээнд тусгагдсан Дэлхийн болон бүс нутгийн стратегитэй уялдуулан малын голлох халдварт өвчнүүдийн тандалтын болон тэмцэх стратегиуд боловсруулах, мөн үхрийн цээж, шүлхий, БММӨ-гүй, тайван статусыг ДМАЭМБ-д хүлээн зөвшөөрөх баримт бичгийг эцэслэх үйл ажиллагааны хүрээнд МААЭЗЭН төслийн 2020-2023 оны үйл ажиллагааны үр нөлөөг бруцеллёзын ийлдсийн тандалтаар хэмжихээр заасан нь төлөвлөлтийн алдаатай арга хэмжээ болсон гэж үзэж байна.</li> <li>2. Мөн дээрх гэрээнд тусгагдсан малын ялган бүртгэх системийг Мал эмнэлгийн гэрчилгээний системтэй уялдуулах талаар хянаж үзэх, үүн дээр үндэслэн үндэсний нэгдсэн бүртгэлийн нэгдсэн систем болгон хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Мал эмнэлгийн хүний нөөцийн нэгдсэн систем хийхээр шийдвэрлэсэн нь төлөвлөсөн арга хэмжээтэй уялдахгүй байна.</li> <li>3. Бүрэлдэхүүн хэсэг 2-ын үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай.</li> <li>4. Төслийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшинг хэмжигдэхүйц байдлаар тусгаагүй нь үнэлгээ хийхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.</li> </ol> |                     |                     |                     |                     |
| 8  | Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ                             | Малын эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг ХХААХҮЯ, МЭЕГ-аас барьж байгаа бодлоготой нийцүүлэх, МЭЕГ-ын төсвийн хүрээнд хэрэгжүүлж байгаа ажлыг давхардуулан хэрэгжүүлж төсвийн үр зардал гаргахаас зайлсхийх, харилцаа хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай.   |                     |                     |                     |                     |
| 9  | Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)<br>Төсөл хэрэгжиж эхэлснээс хойших үнэлгээгээр | Биелэлт дундаж  | Бүрэлдэхүүн хэсэг 1 | Бүрэлдэхүүн хэсэг 1 | Бүрэлдэхүүн хэсэг 1 | Бүрэлдэхүүн хэсэг 4 |
|    |  | 80.4  | 80.0                | 50.0                | 91.7                | 100.0               |
| 10 | Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)   | Нэгдсэн үнэлгээ   |                     |                     |                     |                     |
|    |  | ... %   |                     |                     |                     |                     |

## **ХОЁР. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.**

### **2.1. ТӨСЛИЙН ТУХАЙ.**

Манай улсад 2013-2017 оны хооронд Дэлхийн банкны 11.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Хөдөө аж ахуйн маркетинг” төсөл Хөвсгөл, Завхан, Архангай, Говь-Алтай, Баянхонгор гэсэн 5 аймгийн 15 суманд хэрэгжиж, малчдыг зах зээл, хэрэглэгчидтэй шууд холбох, мал сүргийн үржлийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн салбарын өртгийн сүлжээг хөгжүүлэх арга хэмжээнд голчлон анхаарсан бөгөөд тус төсөлд 14.0 мянга орчим малчид хамрагдаж, малчдын малын мах, сүү, ноос, ноолуураас олох орлого дунджаар 78 хувиар нэмэгдсэн байдаг.

Малын эрүүл мэнд, үр ашиг, бүтээмж болон төсөл хэрэгжих газрууд дахь нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор

- 1) Малын эрүүл мэндийн үйлчилгээ,
- 2) Өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлт,
- 3) Төслийн хэрэгжилтийг дэмжих,

4) Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээ гэсэн 4 бүрэлдэхүүн хэсгийг ХХААХҮЯ, МЭЕГ болон бусад ашиг хүртэгч нартай хамтран хэрэгжүүлнэ.

Төслийн хэрэгжүүлэлт: Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Дэлхийн банкны суурин төлөөлөгч Андрей Михнев нар Дэлхийн банкны 30.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн Санхүүжилтийн хэлэлцээрт 2020 оны 2 дугаар сарын 7-ны өдөр гарын үсэг зурсан.

“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийг Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Булган, Орхон, Архангай, Өвөрхангай, Төв, Хэнтий, Сүхбаатар гэсэн 14 аймгийн 150 сум болон Улаанбаатар хотод хэрэгжинэ.

Төслийн удирдах хороог ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А-320 дугаар тушаалаар байгуулсан.

### **2.2. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.**

Төлөвлөсөн арга хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан, тэдгээрийн хоорондын зөрүүг илрүүлэн дүн шинжилгээ хийж шалтгааныг тодруулах, бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулж, гадаад зээлийн үр дүн, үр ашиг, ил тод байдлыг дээшлүүлэхэд оршино.

### **2.3. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2020 оны жилийн эцсийн тайланг судлах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтантай ярилцах, холбогдох газраас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

## **ГУРАВ. ТӨСЛИЙН ХҮРЭЭ.**

**3.1. Төслийн хүрээ.** Төсөлд 14 аймгийн 150 сум болон Улаанбаатар хотыг хамран хэрэгжинэ.

**3.2. Төслийн нийт төсөв.** Дэлхийн банкнаас 30.0 сая ам доллар зарцуулахаар төсөвлөсөн.

### **3.3. Хүлээгдэж буй үр дүн**

**БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1.** Малын эрүүл мэндийн үйлчилгээ.

Шалгуур үзүүлэлт 1.1. Шүлхий, бог малын мялзан зэрэг өвчний тархалтыг 20-оос доошгүй хувиар бууруулах,

**БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2.** Нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх,  
Шалгуур үзүүлэлт

2.1. Малын гаралтай бүтээгдэхүүний гарцын өсөлтийг 10 хувьд хүргэх,

2.2. Бог малын амьдын жингийн өсөлтийг 10 хувьд хүргэх,

2.3. Сүүний гарцын өсөлтийг 10 хувьд хүргэх,

2.4. Малын гаралтай бүтээгдэхүүний инфляцаас цэвэршүүлсэн үнэ цэнийн өсөлтийн зөрүүг 20 хувьд хүргэх

**3.4. Төсөл хэрэгжих хугацаа.** Төсөл 2020 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд хэрэгжинэ.

### **3.5. Төслийн санхүүжилт.**

Төслийн 4 бүрэлдэхүүн хэсэг болон удирдлагын зардалд зориулан 2020 онд 5,767,344,800.0 төгрөг төсөвлөж, 5,257,792,655.0 төгрөг зарцуулж, санхүүжилтийн гүйцэтгэл 91.2 хувийн биелэлттэй байна. Төслийн төлөвлөсөн нийт санхүүжилтээс 2020 онд 6.15 хувийг зарцуулсан байна.

**ДӨРӨВ. ТӨСЛИЙН 2020 ОНЫ ХЭРЭГЖИЛТ.**

**БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1: МАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

| Дд | Хийгдэх ажил  | Гүйцэтгэл  | Үр дүн   |
|----|---|--|--|
| 1  | НҮБ-ын ХХААБ-тай байгуулах гэрээний төслийг боловсруулж, хэлэлцээ хийж, Үр дүнгийн гэрээ байгуулж, үндэсний болон бүсийн лавлагаа лабораториудад үнэлгээ хийх, эмнэлгийн салбарын боловсролын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, чадавх бэхжүүлэх ажлыг эхлүүлэх.  | НҮБ-ын ХХААБ-тай байгуулах гэрээний төслийг боловсруулан, хэлэлцээ хийж, Үр дүнгийн гэрээ байгуулж, ажлыг эхлүүлээ.  | МААЭЗЭН төслийн туслан гүйцэтгэгчээр ажиллах ХХААБ-тай хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан, хэлэлцээр хийсний дүнд үр дүнд 2020 оны 6 дугаар сард Үр дүнгийн гэрээ байгуулсан.   |
| 2  | ДМАЭМБ-ын Мал эмнэлгийн үйлчилгээний гүйцэтгэлийн үнэлгээ, ДЭМБ-ын Хамтарсан хөндлөнгийн үнэлгээ, Эпидемиологийн зураглалын үнэлгээ (epidemiological mapping tool ЕМТ) гэх мэт өмнөх үнэлгээнүүдээс гарсан тэргүүлэх зөвлөмжүүд болон ХДХӨ-ний ахисан түвшний үнэлгээ, бусад мэдээллийг хянах, хэрэгжүүлэх. | Монгол Улсын мал эмнэлгийн салбарт хийгдсэн олон улсын үнэлгээнүүдийн дүгнэлтийг нэгтгэж, үнэлгээний хураангуйг 2020 оны 10 сарын 29-ний өдөр төслийн Техникийн ажлын хэсгийн гишүүдэд танилцуулсан.   | Техникийн ажлын хэсгийн гишүүд олон улсын үнэлгээний хураангуйтай танилцаж төслийн зүгээс нэн яаралтай авч хэрэгжүүлэх дараах 4 үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон. Малын эмч нарын итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох, Мал эмнэлгийн лабораторийн хэрэгцээ, шаардлагыг үнэлэх, Малын халдварт өвчний тандалтын тогтолцоог боловсронгуй болгох, Мал эмнэлгийн салбарт халдварт өвчний эрсдэлийн үнэлгээ хийдэг тогтолцоо бий болгох |
| 3  | Дэлхийн болон бүс нутгийн стратегитай уялдуулан малын голлох халдварт өвчнүүдийн тандалтын болон тэмцэх стратегиуд боловсруулах, үхрийн цээж, шүлхий, БММӨ-гүй эрүүл статусыг ДМАЭМБ-д хүлээн зөвшөөрөх баримт бичгийг эцэслэх.   | МЭЕГ-ын боловсруулсан Монгол Улсын баруун бүсийн 7 аймгийг шүлхий өвчний халдваргүй болохыг баталгаажуулах баримт бичгийг хянаж холбогдох санал өгсөн. 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мал эмнэлгийн тандалтын тогтолцоонд үнэлгээ хийх Үндэсний зөвлөхийг сонгон шалгаруулж хамтран ажиллаж байна. Тус үндэсний зөвлөх нь манай оронд зонхилон тохиолддог гоц халдварт, халдварт ба зоонз өвчний идэвхтэй болон | Монгол Улсын баруун бүсийн 7 аймгийг шүлхий өвчний халдваргүй болохыг баталгаажуулах баримт бичгийг ДМАЭМБ-д илгээх бэлтгэл хангагдсан. МААЭЗЭН төслийн 2020-2023 оны үйл ажиллагааны үр нөлөөг бруцеллёзын ийлдсийн тандалтын суурь судалгаагаар хэмжих юм. Иймд энэхүү тандалтыг МААЭЗЭН төслийн зорилтот болон зорилтот бус аймгуудад хийсэн бөгөөд   |

|   |   |  |   |
|---|---|--|---|
|   |   | <p>идэвхгүй тандалтын явцын суурь түвшнийг тодорхой аргаар зориулсан үнэлэх ажлыг зохион байгуулна.</p> <p>Мөн малын голлох халдварт өвчнүүдийн тандалтын тогтолцоонд оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг нарийн тодорхойлох, удирдамж, аргаар заавар, зөвлөмжийг оновчтой боловсруулах ажлууд хийгдэнэ.</p>  | <p>үхэр болон бог малын дундах халдварын түвшнийг тогтооход чиглэгдсэн.</p> <p>Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Хөвсгөл, Баянхонгор, Сүхбаатар (төслийн зорилтот аймаг) Сэлэнгэ, Дундговь (төслийн зорилтот бус аймаг) нийт 8 аймаг, 16 сумын нийт 6400 нас гүйцсэн малаас дээж авч, шинжилгээ хийсэн. Илрүүлэх шинжилгээ буюу розебенгалийн шинжилгээ хийгдэж дууссан бөгөөд аймаг тус бүрд авсан 800 дээжээс эерэг үр дүн дараах байдлаар илэрсэн. Баталгаажуулах шинжилгээ хийгдэж байна.</p> <p>- Баян-Өлгий 7, Баянхонгор – 36, Говь-Алтай – 4, Дундговь – 15, Завхан – 1, Сүхбаатар – 8, Сэлэнгэ – 12, Хөвсгөл - 7 дээж эерэг.</p> |
| 4 | <p>Малын эмч, малын бага эмч нарт зориулсан сургалтын хэрэгцээний үнэлгээ хийх, дор хаяж 50 сургагч багшид зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт явуулах.</p> | <p>Мал эмнэлгийн салбарын боловсролын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, чадавч бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, мал эмнэлгийн үргэлжилсэн сургалтын тогтолцоонд үнэлгээ хийх үүрэгтэй ажиллах Үндэсний зөвлөхийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулан, 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хамтран ажиллаж байна.</p> <p>Төслийн хүрээнд 2020-2025 он хүртэл 20 чиглэлээр сургалт явуулж 3105 ашиг хүртэгчийг сургалтад хамруулах төлөвлөгөө боловсруулсан. Сургалтыг Мал эмнэлгийн сургууль, Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний Байгууллага, Мал аж ахуйн биотехнологийн сургууль зэрэг сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулна. Малын эмч нар, шинэ залуу малын эмчийг танхимын болон талбарын сургалтаар чадваржуулах юм.</p> | <p>Үндэсний зөвлөх нь төрийн болон хувийн хэвшлийн малын эмч, малын бага эмч, мал эмнэлгийн техникчдийн төлөөлөл болсон 40 орчим хүний бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлгийг хоёр үе шаттай зохион байгуулсан.</p> <p>Малын эмч нар, шинэ залуу малын эмч нарыг чадавхжуулах 2020-2025 оны сургалтын төлөвлөгөө боловсруулаад байна.</p>   |
| 5 | <p>Малын гаралтай хоол хүнс, хил дамжин халдварлах өвчний эрсдэлд суурилсан тандалтын системийг бий болгох.</p>   | <p>Хил дамжин халдварлах өвчний эрсдэлд суурилсан тандалтын тогтолцоо бий болгох судалгааны ажлын баримт бичгийг боловсруулан Техникийн ажлын хэсгийн гишүүдэд танилцуулав.</p>  | <p>Тус эрсдэлийн тогтолцооны судалгааны ажлыг Ховд, Өвөрхангай болон Сүхбаатар аймагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарсан.</p>  |

|   |  |  |   |
|---|--|--|---|
| 6 | Лабораторийн байгууламжийг сайжруулах хэрэгцээ, чадавхын үнэлгээ, чанарын баталгаа, ур чадварын тест, биоаюулгүй байдлыг сайжруулах, биоинформатик, лабораторийн сүлжээг багтаасан лабораторийн чадавхыг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.; | 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мал эмнэлгийн лабораторийн тогтолцоонд үнэлгээ хийх Үндэсний зөвлөхийг сонгон шалгаруулж хамтран ажиллаж байна.<br>Мал эмнэлгийн лабораторийн оношилгооны өнөөгийн түвшнийг олон улсын шаардлагад нийцүүлэн үнэлэх ажилд НҮБ-ын ХХААБ-ын ХХААБ ЛҮА ашиглахаар шийдвэрлэсэн.<br>Тус үнэлгээнд малын эрүүл мэндийн тандалт, нянгийн тэсвэржилтийн тандалт, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний 4, бүсийн 2, мөн 6 аймгийн мал эмнэлгийн лаборатори хамрагдана. | 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 8 аймаг (Баянхонгор, Булган, Дорнод, Завхан, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Хэнтий)-ийн МЭЛ, МЭЭСБУЛ, НМЭГ-ын лабораторийн эрхлэгч, чанарын менежер, ажилтан нартай цахимаар (ZOOM) холбогдож ХХААБ ЛҮА-ын товч танилцуулга хийн, үнэлгээний бэлтгэл ажлын талаар санал солилцлоо. |
| 7 | Малын ялган бүртгэх систем (AIRS) -ийг Мал эмнэлгийн гэрчилгээний систем (VCS) -тэй уялдуулах тараар хянаж үзэх, үүн дээр үндэслэн үндэсний нэгдсэн бүртгэлийн нэгдсэн систем болгон хөгжүүлэх   | ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А-385 дугаар тушаалаар “Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор “Мал эмнэлгийн хүний нөөцийн нэгдсэн систем”-ийг бий болгох ажлыг Төслийн дэмжлэгтэйгээр хийхээр шийдвэрлэсэн.  | Төслийн техникийн ажлын хэсгийн 2020 оны 10 дугаар сарын 29-ний хурлаар “Мал эмнэлгийн хүний нөөцийн нэгдсэн систем”-ийг ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.   |

**БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2: ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТ**

| Дд | Хийгдэх ажил   | Гүйцэтгэл  | Үр дүн   |
|----|--|--|--|
| 1  | Өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд холбогдох баримт бичгийг мал аж ахуйн талаар баримтлах бодлого, стратеги, төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг эхлүүлэх, нэмүү өртгийн сүлжээний дэд төслүүдэд хамрагдаж буй иргэдэд шаардлагатай сургалтын хөтөлбөр боловсруулах. | Дэд төслүүдийг сонгон шалгаруулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангав. Үүнд:<br><ul style="list-style-type: none"> <li>• Төрөөс мал аж ахуйн талаар баримталж буй бодлого, стратеги, төлөвлөгөөний талаар ХХААХҮЯ-ны холбогдох газар, хэлтсийн мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, мал аж ахуйн бодлого, стратегийг төсөлтэй уялдуулахад анхааран ажиллалаа.</li> <li>• Малын үржил, тэжээлийн чиглэлээр дэд төслүүд хүлээн авахад баримтлах үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлалыг Малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөө, бусад холбогдох дүрэм, журамд нийцүүлэн боловсруулаад байна,</li> <li>• Дэд төслүүдийг сонгон шалгаруулалтын үйл явцын зураглалын төслийг боловсруулав,</li> </ul> | Дэд төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан ДБ-ны төсөл хариуцсан мэргэжилтнүүдтэй олон удаагийн цахим уулзалт хийж, хэлэлцсэний үр дүнд дараах баримт бичгийг боловсруулан, эцсийн хувилбарт зөвшөөрөл авахаар ДБ-нд хүргүүлээд байна.<br><ul style="list-style-type: none"> <li>• Дэд төслүүдийг сонгон шалгаруулалтын үйл явцын зураглалын төсөл,</li> <li>• Бүтээмжит түншлэлийн заавар (PPM)-ыг эцэслэн батлуулахад бэлэн болгож, дэд төслүүд хүлээн авахад баримтлах үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд,</li> <li>• Дэд төслүүдэд зориулан байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний төсөл.</li> </ul> Мах, сүүний нэмүү өртгийн сүлжээнд оролцогчид болон дэд төслүүдийг сонгон шалгаруулалтад |

|   |   |   |  |
|---|---|---|--|
|   |   | <ul style="list-style-type: none"> <li>• Бүтээмжит түншлэлийн заавар (PPM)-ыг эцэслэн батлуулахад бэлэн болгож, дэд төслүүд хүлээн авахад баримтлах үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлов,</li> <li>• Дэд төслүүдэд зориулан байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө боловсруулах боловсруулав,</li> <li>• Мах, сүүний нэмүү өртгийн сүлжээнд оролцогчид болон дэд төслүүдийн сонгон шалгаруулалтад оролцогчдод зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулав,</li> <li>• Дэд төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилчдад Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээний танилцуулах сургалт хийсэн,</li> <li>• Бүтээмжит төслийн бүрэлдэхүүн хэсгийг олон нийтэд таниулан, сурталчлах ажлын бэлтгэл хангасан,</li> <li>• Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэх зөвлөх байгууллага сонгон шалгаруулах ажлын даалгавар бэлтгэсэн.</li> </ul> | <p>оролцохыг хүсэгч нарт зориулсан сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулсан.</p> <p>Бүтээмжит төслийн ашиг хүртэгчид, үржлийн аж ахуйн нэгжүүдэд сургалтаар дамжуулан малчин, фермерүүдийг үр ашигтай, байгаль орчинд ээлтэй, тооноос чанарт шилжих, нэгжээс авах үр өгөөжийг дээшлүүлэхэд мэргэжлийн зөвлөх үйлчилгээний байгууллага, Хувийн мал эмнэлэг, Хувийн үржлийн нэгж, ХААИС-ийн МЭС, МААБТС зэрэг мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт явуулах арга зүй батлуулах, сургалтад хамрагдсан ашиг хүртэгчдийг бүртгэлжүүлэх, тайлагнах журам боловсруулсан.</p> <p>Дэд төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилчдад Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээний танилцуулах сургалт хийсэн.</p> |
| 2 | <p>Төслийн гүйцэтгэлийн хяналтын системийг хөгжүүлж, ашиг хүртэгчид, ажлын хэсгүүд, ТНХ-ийн ажиллагсад тогтмол тайлан, төлөвлөлт зэрэг хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаатай холбоотой зааварчилгааг өгч, дэмжлэг үзүүлэх</p> | <ul style="list-style-type: none"> <li>• Мал эмнэлгийн салбарт хэрэгжиж байгаа цахим системүүдэд (MAHIS, AIRIS) үнэлгээ хийх, эдгээр системийг нэгтгэх боломжийн талаар зөвлөмж боловсруулах, цахим системийг цаашид хэрхэн сайжруулах талаар зөвлөмж боловсруулах үүрэгтэй ажиллах Үндэсний зөвлөхийн ажлын даалгавар боловсруулсан.</li> <li>• Гар утсаар дамжуулж мал эмнэлгийн үйлчилгээг бүртгэлжүүлэх, малчин, малын эмчилгээ үйлчилгээний захиалга өгөх, үржлийн нэгж цөм сүргийн бүртгэл бий болгох, малын гаралтай түүхий эдийн бүртгэлийн нэгдсэн сан бүрдүүлэх болон бусад төрлийн үйлчилгээ цахимаар авах боломжийг бүрдүүлэх гар утасны программ, аппликэйшн хийх бэлтгэл ажил хийгдэж байна.</li> </ul>   | <p>Гар утсаар дамжуулж мал эмнэлгийн үйлчилгээг бүртгэлжүүлэх, малчин, малын эмчилгээ үйлчилгээний захиалга өгөх, үржлийн нэгж цөм сүргийн бүртгэл бий болгох, малын гаралтай түүхий эдийн бүртгэлийн нэгдсэн сан бүрдүүлэх болон бусад төрлийн үйлчилгээ цахимаар авах боломжийг бүрдүүлэх гар утасны программ, аппликэйшн хийх хар зургийг бэлтгэсэн.</p>  |

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3: ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖИХ

| Дд | Хийгдэх ажил | Гүйцэтгэл | Үр дүн |
|----|--------------|-----------|--------|
|----|--------------|-----------|--------|



|          |  |   |  |
|----------|--|---|--|
| <p>1</p> | <p>МАОЭЗЭН төслийн эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд холбогдох баримт бичгийг боловсруулах, Төслийн удирдах хороог байгуулж, төслийн зөвлөхүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах.</p> | <p>ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны 03 сарын 18-ны өдрийн А-100 дугаар тушаалаар МАОЭЗЭН Төслийн удирдах хороог байгуулж, захирлыг томилсон бөгөөд 2020 оны 10 сарын 30-ны өдрийн А-320 дугаар тушаалаар Төслийн үнэлгээний хороог шинэчлэн байгуулсан.</p> <p>ХХААХҮЯ-ны ТБНД-ын 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А-92 дугаар тушаалаар байгуулагдсан МАОЭЗЭН төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн холбогдох ажилтнуудыг сонгон шалгаруулах, төслийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой тоног төхөөрөмж, эд хогшлын худалдан авалтыг ДБ-ны худалдан авалтын журмаар зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>МЭЕГ-ын даргын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/221 дүгээр тушаалаар төслийн Техникийн ажлын хэсэг байгуулсан.</p> <p>ХХААБ-тай байгуулах гэрээний төслийг боловсруулж, хэлэлцээ хийж, үр дүнгийн гэрээ байгуулсан.</p> <p>Холбогдох тушаал гарч, бичиг баримтыг боловсруулж ажилласны үр дүнд ДБ 2020 оны 6 дугаар сарын 7-ны өдөр МАОЭЗЭН төслийг хүчин төгөлдөр гэж зарлав.</p> | <p>Төслийн хэрэгжилтийг чиглүүлэх баримт бичгүүдийг Санхүүжилтийн хэлэлцээртэй уялдуулан боловсруулж, ДБ-аар батлуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төслийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (ESMF) бодлогын баримт бичиг,</li> <li>• Төслийн худалдан авалтын хөгжлийн стратеги (PPSD) бодлогын баримт бичиг</li> <li>• Төсөл хэрэгжүүлэх заавар (PIM),</li> <li>• Бүтээмжит түншлэлийн заавар (PPM)</li> <li>• Болзошгүй онцгой байдлын удирдлагын заавар,</li> <li>• Санхүүгийн удирдлагын заавар (FMM),</li> <li>• Залуу мэргэжилтэн хөтөлбөрийн бодлого (YPP),</li> <li>• Төслийн худалдан авалтын 18 сарын төлөвлөгөө,</li> <li>• Олон нийтийн харилцаа, сурталчилгааны бодлого.</li> </ul> <p>МАОЭЗЭН нь төслийн удирдах хороо байгуулах, төслийн захирал томилох ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны 03 сарын 18-ны өдрийн А-100 дугаар тушаалаар МАОЭЗЭН Төслийн удирдах хороог байгуулж, захирлыг томилсон бөгөөд 2020 оны 10 сарын 30-ны өдрийн А-320 дугаар тушаалаар Төслийн үнэлгээний хороог шинэчлэн байгуулсан.</p> <p>ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А-92 дугаар тушаалаар байгуулагдсан МАОЭЗЭН төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн холбогдох ажилтнуудыг сонгон шалгаруулах, төслийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой тоног төхөөрөмж, эд хогшлын худалдан авалтыг ДБ-ны худалдан авалтын журмаар зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/221 дүгээр тушаалаар МАОЭЗЭН төслийн Техникийн ажлын хэсэг байгуулсан. ХХААБ-тай байгуулах гэрээний</p> |
|----------|--|---|--|

|   |  |   |   |
|---|--|---|---|
|   |  |   | төслийг боловсруулж, хэлэлцээ хийж, Үр дүнгийн гэрээ байгуулсан.<br>Холбогдох тушаал гарч, бичиг баримтыг боловсруулж ажилласны үр дүнд ДБ 2020 оны 6 дугаар сарын 7-ны өдөр МААЭЗЭН төслийг хүчин төгөлдөр гэж зарлав.   |
| 2 | Төслийн хэрэгжилтийг чиглүүлэх баримт бичгүүдийг Санхүүжилтийн хэлэлцээртэй уялдуулан боловсруулах   | Төслийн хэрэгжилтийг чиглүүлэх баримт бичгүүдийг Санхүүжилтийн хэлэлцээртэй уялдуулан боловсруулсан.<br>Үүнд:<br><ul style="list-style-type: none"> <li>• Төслийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (ESMF) бодлогын баримт бичиг,</li> <li>• Төслийн худалдан авалтын хөгжлийн стратеги (PPSD) бодлогын баримт бичиг</li> <li>• Төсөл хэрэгжүүлэх заавар (PIM),</li> <li>• Бүтээмжит түншлэлийн заавар (PPM)</li> <li>• Болзошгүй онцгой байдлын удирдлагын заавар,</li> <li>• Санхүүгийн удирдлагын заавар (FMM),</li> <li>• Залуу мэргэжилтэн хөтөлбөрийн бодлого (YPP),</li> <li>• Төслийн худалдан авалтын 18 сарын төлөвлөгөө,</li> <li>• Олон нийтийн харилцаа, сурталчилгааны бодлого.</li> </ul>                     | Төслийн хэрэгжилтийг чиглүүлэх баримт бичгүүдийг Санхүүжилтийн хэлэлцээртэй уялдуулан боловсруулж, ДБ-аар батлуулсан. Үүнд:<br><ul style="list-style-type: none"> <li>• Төслийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ (ESMF) бодлогын баримт бичиг,</li> <li>• Төслийн худалдан авалтын хөгжлийн стратеги (PPSD) бодлогын баримт бичиг</li> <li>• Төсөл хэрэгжүүлэх заавар (PIM),</li> <li>• Бүтээмжит түншлэлийн заавар (PPM)</li> <li>• Болзошгүй онцгой байдлын удирдлагын заавар,</li> <li>• Санхүүгийн удирдлагын заавар (FMM),</li> <li>• Залуу мэргэжилтэн хөтөлбөрийн бодлого (YPP),</li> <li>• Төслийн худалдан авалтын 18 сарын төлөвлөгөө,</li> <li>• Олон нийтийн харилцаа, сурталчилгааны бодлого.</li> </ul> |
| 3 | Төслийн удирдлагын зөвлөмжийн дагуу худалдан авалтыг төлөвлөгөөг тогтмол шинэчлэн боловсруулах, шаардлагатай тохиолдолд өрсөлдөөнд тендер шалгаруулалтаар ажил болон барааны худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх (тендерийн баримт бичгийг бэлтгэх, шалгуурын дагуу бараа болон ажил гүйцэтгэгчийг сонгох, гэрээний хэлцлийг хийх, гэрээ бэлтгэх) мөн Төслийн санхүүжилтийн хэлэлцээрт заасан Техникийн үйлчилгээ үзүүлэгч нарыг ХОТС-н зээлдэгч нарт зориулсан ДБ-ны худалдан авах | 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн ХХААХҮЯ-ны болон ДБ-ны баталсан худалдан авалтын шинэчилсэн төлөвлөгөөнд багтсан зөвлөхүүдийн ажлын даалгаврыг боловсруулж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, зөвлөхүүдийн ажлыг эхлүүлээд байна. Мөн төслийн Хуулийн зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулан, сонгон шалгаруулалтыг эхлүүлээд байна. Дэд төслийн баримт бичгүүдийг хянах, гэрээний загварыг боловсруулах хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага боловсруулсан. Улмаар зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулах үнэлгээний хороо 2020 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн ХХААХҮ-ийн ТНБД-ын А-300 дугаар тушаалаар байгуулагдаж, ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг хэлэлцэн баталж, зарлах ажил явагдаж байна. | Төсөл хэрэгжүүлэх нэгжийн нийт ажилтны сонгон шалгаруулалт зохион байгуулж, ажлыг эхлүүлсэн.<br><ul style="list-style-type: none"> <li>- Төслийн зохицуулагч,</li> <li>- Эдийн засагч санхүүгийн шинжээч,</li> <li>- Санхүүгийн удирдлагын мэргэжилтэн,</li> <li>- Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн,</li> <li>- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аюулгүйн арга хэмжээний мэргэжилтэн,</li> <li>- Олон нийтийн харилцаа, сурталчилгааны мэргэжилтэн,</li> <li>- Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээ, бүтээмжит түншлэлийн мэргэжилтэн,</li> <li>- Шинжлэх ухааны ололт амжилтыг хөдөө аж ахуйд нэвтрүүлэх ажилтан,</li> </ul>   |

|          |   |  |  |
|----------|---|--|--|
|          | <p>ажиллагааны журмын дагуу ажилд авах.</p>   |  | <p>- Байгаль орчин нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн,<br/>- Хэвлэл мэдээллийн ажилтан,<br/>- Газарзүйн мэдээллийн системийн ажилтан,<br/>- Олон нийттэй харилцах стратегийн мэргэжилтэн.<br/>Түүнчлэн төслийн онцлогт тохирсон санхүүгийн программ, Төслийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод явуулах, сурталчлах зорилгоор вэб хуудас хийх, Хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх, Удирдлагын мэдээллийн систем хөгжүүлэх мэдээллийн технологийн компанийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, ажлыг эхлүүлээд байна.</p> |
| <p>4</p> | <p>Төслийн гүйцэтгэлийн хөндлөнгийн болон дотоод хяналтын системийг хөгжүүлж, ашиг хүртэгчид, ажлын хэсгүүд, ТНХ-ийн ажиллагсад тогтмол тайлан, төлөвлөлт зэрэг хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаатай холбоотой зааварчилгааг өгч, дэмжлэг үзүүлэх.</p> | <p>Төслийн суурь судалгаа, хөндлөнгийн үнэлгээ хийх SICA компанийн суурь судалгааны Техникийн болон Санхүүгийн саналыг хүлээн авч танилцан, холбогдох саналыг хүргүүлээд байна. Тус компаниас тоон болон чанарын хоёр төрлийн судалгаа хийх санал ирүүлсэн. Тоон судалгааны хүрээнд төсөл хэрэгжих кластер судалгаа хийхээр сонгосон 8 аймгийн 33 сумын 1020 өрхөөс судалгаа авах, чанарын судалгааны хүрээнд холбогдох Засгийн газрын нэгж, хувийн хэвшил, гол үйлдвэрлэгчдийн дунд хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүлэн 4 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ. Суурь судалгаа нь дараах үе шаттай байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Асуулга боловсруулах,</li> <li>2. Мэдээлэл цуглуулах программыг турших (таблет ашиглана),</li> <li>3. Судалгаа авах төлөөлөгчдийг сургах,</li> <li>4. Судалгаагаа туршиж, асуулгаа эцэслэх,</li> <li>5. Таблет ашиглан өрхийн судалгаа, ярилцлагыг бодит цагийн горимоор мэдээллээ илгээх,</li> <li>6. Мэдээлэл боловсруулах.</li> </ol> <p>ДБ-наас зөвшөөрөл авч, SICA компанитай гэрээ байгуулан, суурь судалгааны тайланг хүлээн авсан.</p> | <p>Төслийн хөндлөнгийн хяналт-шинжилгээ үнэлгээ хийх SICA компаний суурь судалгааны асуулгын төслийг зөвшилцөн, суурь судалгааны санал асуулгыг Төв аймагт туршиж, судалгааг эхлүүлээд байна.<br/>Төслийн удирдлагын мэдээллийн систем хөгжүүлэх мэдээллийн технологийн компаний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, ДБ-наас зөвшөөрөл аваад байна.</p>   |

|   |   |   |   |
|---|---|---|---|
|   |   | Удирдлагын мэдээллийн систем нь төслийн явцыг Төслийн хөгжлийн зорилт, төслийн индикаторуудад үндэслэн үнэлэх, төслийн явцын аль нэг үед асуудал гарсан бол түүнийг олж илрүүлэх, шинжилгээ хийх, нэгтгэхэд туслах зорилготой хэрэглэхэд хялбар, энгийн хэрэглээний компьютерт нийцсэн, веб орчинд суурилсан, төслийн бүх оролцогч талууд хандах, мэдээлэл оруулах боломжтой мэдээллийн бааз байхаар ажлын даалгавар боловсруулсан. |   |
| 5 | Төслийн санхүүгийн удирдлагын хүрээг боловсруулж, төсвийг зохистойгоор хуваарилах, мөн ДБ-ны шаардлагад нийцүүлэн ЗД (Зориулалтын данс) болон ДД (Дэд данс)-г тохируулах. Санхүүгийн удирдлагын систем ашиглан бүх төрлийн тайланг боловсруулж, нягтлан бодох бүртгэлийн бичилт болон хөрөнгийн менежментийг тухай бүр нь хөтлөх. | МАНЭЭЭН төслийн онцлогт тохирсон санхүүгийн программ боловсруулах ажлын даалгавар боловсруулсан. Түүнчлэн бүх төрлийн санхүүгийн тайланг боловсруулж, нягтлан бодох бүртгэлийн болон хөрөнгийн менежментийг хийж ажилласан.   | МАНЭЭЭН төслийн онцлогт тохирсон санхүүгийн программ боловсруулах ажлын даалгавар боловсруулж, ДБ-ны худалдан авах ажиллагааны харьцуулалтын аргаар үнэлгээ хийж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, Диктум Фактум ХХК-тай гэрээ байгуулсан.<br>Төслийн санхүүгийн тайланг Монгол улсын болон ДБ-ны стандартын дагуу гарган хүргүүлж, хөндлөнгийн аудитаар баталгаажуулаад байна. |
| 6 | Харилцаа холбооны стратегийг төлөвлөн боловсруулах, аудио, видео, болон хэвлэмэл материалуудыг бэлтгэж төслийн үйл ажиллагааг олон нийтэд бүх төрлийн мэдээллийн сувгаар хүргэх.  | Төслийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод явуулах, сурталчлах зорилгоор вэб хуудас хийхээр төлөвлөн нийлүүлэгчийн ажлын даалгавар боловсруулсан.  | Төслийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод явуулах, сурталчлах зорилгоор вэб хуудас хийхээр төлөвлөн нийлүүлэгчийн ажлын даалгавар бэлтгэж, сонгон шалгаруулалт хийгдэж гэрээ байгуулагдсан. Иймд <a href="http://www.lcp.mn">www.lcp.mn</a> вэб хуудас хийгдэж бэлэн болгоод байна.   |

**БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 4: БОЛЗОШГҮЙ ОНЦГОЙ БАЙДЛЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ**

| Дд | Хийгдэх ажил  | Гүйцэтгэл   | Үр дүн   |
|----|---|---|--|
| 1  | УОК-ын Зудын эрсдэлийн үнэлгээгээр Баянхонгор, Өвөрхангай, Дундговь аймгууд, Говь-Алтай, Өмнөговь аймгийн зарим сумд “маш их”, “их” зудын эрсдэлтэй гэсэн үнэлгээ авсан бөгөөд уг дүгнэлтийг мэдээлсэн. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 | Бүрэлдэхүүн хэсэг идэвхжүүлэх ажлын хүрээнд Зудын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээтэй холбоотой Үйл ажиллагааны урьдчилсан төлөвлөгөө, Үр нөлөөний түргэвчилсэн үнэлгээг боловсруулан, зардлын дахин хуваарилах хүсэлтийг ДБ-нд илгээсэн. | Засгийн газрын 2020 оны 213 дугаар тогтоол гарсантай холбогдуулан хариу арга хэмжээг хэрэгжүүлэх Үр нөлөөний түргэвчилсэн үнэлгээ, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ДБ-наас зөвшөөрөл 2020 оны 12 сарын 30-ны өдөр хүлээн авч төслийн санхүүжилтийн эх үүсвэрээс хариу арга |

|          |   |  |   |
|----------|---|--|---|
|          | <p>сарын 16-ны өдрийн хуралдаанаар байгалийн гамшигт нөхцөл байдал бий болсон гэж үзэж, уг нөхцөл байдлын хариу арга хэмжээг Болзошгүй онцгой нөхцөл байдал, гамшгийн бүрэлдэхүүн хэсэгт хамруулах тухай Засгийн газрын 213 дугаар тогтоол гарсан. МААЭЗЭН төсөл (зээлийн дугаар 6508-MN)-ийн Болзошгүй онцгой нөхцөл байдал, гамшгийн үед хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн хэсгийг идэвхжүүлж, удирдан зохион байгуулах.</p> |  | <p>хэмжээнд 5 сая ам.долларын дахин хуваарилалт хийгээд байна.</p>  |
| <p>2</p> | <p>МААЭЗЭН төслийн Болзошгүй онцгой нөхцөл байдал, гамшгийн үед хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн хэсгийг идэвхэжсэнтэй холбогдуулан тусламжийн үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах</p>   | <ul style="list-style-type: none"> <li>- ДБ-ны санхүүжилтээр ХХААХҮЯ-ны хэрэгжүүлж буй МААЭЗЭН төслийн Болзошгүй онцгой байдал, гамшгийн үед хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн хэсгийн 5 сая ам.долларын санхүүжилтээр өвөлжилт хүндэрч байгаа Говь-Алтай, Өмнөговь аймгийн зарим сум, Баянхонгор, Дундговь, Өвөрхангай аймгийн бүх сумын болон отроор явж байгаа малчин өрхөд тэжээл хүргүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах Монгол Улсын Шадар сайдын захирамжийн төсөл болон Мал өвөлжилт хүндэрч байгаа аймгуудын малчин өрхөд малын тэжээл олгох ажлыг зохион байгуулах түр журам, зохион байгуулалтын матрицын төслийг боловсруулан ХХААХҮЯ-нд хүргүүлээд байна. Тэжээл үйлдвэрлэгчидтэй байгуулах санамж бичгийн төслийг боловсруулаад байна.</li> <li>- Зудын эрсдэлтэй 7 аймаг, 74 сум, 45 570 малчин өрхөд тэжээлийн дэмжлэг үзүүлэх тооцоолол хийсэн. Тэжээлийн орц, норм, стандарт, дэмжлэгээр худалдан авах тэжээлийн техникийн үзүүлэлт гаргасан.</li> <li>- Дэмжлэгийн тэжээл үйлдвэрлэгчээс тээвэрлэгч, Улсын онцгой байдлын комиссоор дамжин малчдын гарт очих үйл явцыг хянах, удирдах зорилгоор хөгжүүлэх аппликэйшний хийх төлөвлөгөө, төсөв, хар зургийн төслийг бэлтгэн гүйцэтгэгч компанитай тохиолцоод байна.</li> </ul> | <p>Боловсруулсан баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. ХХААХҮ-ийн Сайд З.Мэндсайханы Өвөлжилт хүндэрсэн аймгуудын онцгой комисстой хийх цахим хуралд хэлэх үгийн төсөл, Хэвлэлийн мэдээний төсөл,</li> <li>2. Аймгийн Засаг дарга, Хөдөө аж ахуйн газрын дарга нарт Тэжээл олгох ажлыг аймаг орон нутгийн түвшинд зохион байгуулах тухай албан тоотын төсөл,</li> <li>3. Тэжээлийн шошго дээр хэвлэх Хүчит тэжээл ашиглах заавар,</li> <li>4. Тэжээл ачих цувааны анонс,</li> <li>5. МААЭЗЭН төслийн танилцуулга, тусламжийн хүчит тэжээлийн зааврын видео контентыг боловсруулан, бэлэн болгосон,</li> <li>6. Тусламжийн үйл ажиллагаатай холбоотой үйлдвэрлэгчээс бараа хүлээн авах ачаа тээврийн баримт, бараа хүлээлцсэн акт, аймгуудад барааг хүлээн авснаас хойш сумдад бараа хүргүүлэхтэй холбоотой агуулахын бүртгэл, аймгийн агуулахаас сумд руу ачих ачаа тээврийн баримт,</li> </ol> |

|  |  |   |
|--|--|---|
|  | <ul style="list-style-type: none"> <li>- МААЭЗЭН төслийн байгаль орчин, нийгмийн хүрээний баримт бичиг, худалдан авах ажиллагааны стратеги, төлөвлөгөөг боловсруулан ДБ-наас зөвшөөрөл авахаар хүргүүлээд байна.</li> <li>- Олон нийттэй харилцах төлөвлөгөөний төсөл, төв болон орон нутгийн телевиз, олон нийтийн сүлжээний судалгаа хийж, удирдлагад танилцуулаад байна.</li> <li>- Төслийн хариу арга хэмжээний төсвийн төслийг боловсруулан СЯ-ны холбогдох газарт хүргүүлэн МААЭЗЭН төслийн 2020 оны төсөвт тусгасан.</li> </ul> | <p>сумдаас малчдад тэжээл тараахтай холбоотой сум дахь агуулахын бүртгэл, малчдад тараах баримт гэх мэт 9 маягт, бүртгэлийн 3 эксель файл,</p> <p>7. Хөндлөнгийн хяналт-шинжилгээ үнэлгээний байгууллага, хэвлэлийн компани, аппликэйшн хийх компанийн ажлын даалгавар боловсруулсан.</p> |
|--|--|---|

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## ТАВ. ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ

/2020 оны жилийн эцсийн байдлаар/

| д/д | Үзүүлэлт              | Хяналт-шинжилгээ, үнэлгээ /хувь/ |      |
|-----|-----------------------|----------------------------------|------|
|     |                       | Арга хэмжээний тоо               | 2020 |
| 1   | Төлөвлөгөөний биелэлт | 13                               | 80.4 |

### ЗУРГАА. ДҮГНЭЛТ

1. Төслийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 80.4 хувьтай дүгнэгдэв.
2. Бүрэлдэхүүн хэсэг 2-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна.
3. Төслийн үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшинг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлоогүй нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.3 дахь заалтын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэл учруулж байна.
4. НҮБ, ХХААБ-тай байгуулагдсан гэрээнд тусгагдсан Дэлхийн болон бүс нутгийн стратегитэй уялдуулан малын голлох халдварт өвчнүүдийн тандалтын болон тэмцэх стратегиуд боловсруулах, мөн үхрийн цээж, шүлхий, БММӨ-гүй, тайван статусыг ДМАЭМБ-д хүлээн зөвшөөрөх баримт бичгийг эцэслэх үйл ажиллагааны хүрээнд МААЭЗЭН төслийн 2020-2023 оны үйл ажиллагааны үр нөлөөг бруцеллёзын ийлдсийн тандалт хийх, түүгээр хэмжихээр заасан нь төлөвлөлтийн алдаа байна.
5. Мөн дээрх гэрээнд тусгагдсан малын ялган бүртгэх системийг Мал эмнэлгийн гэрчилгээний системтэй уялдуулах талаар хянаж үзэх, үүн дээр үндэслэн үндэсний нэгдсэн бүртгэлийн нэгдсэн систем болгон хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Мал эмнэлгийн хүний нөөцийн нэгдсэн систем хийхээр шийдвэрлэсэн нь төлөвлөсөн зорилттой уялдахгүй байна.

### ДОЛОО. ЗӨВЛӨМЖ.

Төслийн хэрэгжүүлэх нэгжид

1. Бүрэлдэхүүн хэсэг 2-ын үйл ажиллагааг эрчимжүүлэх,
2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2.1.7-д заасны дагуу жилийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшинг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж төлөвлөгөөнд тусгах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг ирүүлэх,
3. Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалын 13 дугаар хавсралтын дагуу жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дэлгэрэнгүй тайлан бэлтгэж ирүүлж хэвших,
4. Хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай Төслийн удирдах хорооны шийдвэр гарсан тохиолдолд Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10.13 дахь заалтын хэрэгжилт хангах,
5. Малыг бруцеллёзтой тэмцэх стратеги, төлөвлөгөөг 2015-2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд МЭЕГ-ын төсвийн хүрээнд хэрэгждэг арга хэмжээ тул МААЭЗЭН төслийн хүрээнд энэ мэтээр давхардуулан төлөвлөж, үргүй зардал гаргахгүй байх,
6. НҮБ-ын ХХААБ-тай байгуулсан гэрээний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг салбарын бодлого, төслийн зорилго, зорилтод нийцүүлэх чиглэлд анхаарах,